МОНГОЛ УЛСЫН
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ЯАМ

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,
Утас: 26-22-71, Факс: (976-11) 45-31-21,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2014.01.16 № 01/191

танай ____________-ны №____________-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНД

Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд тус яамнаас гаргах мэдээ, мэдээллийг хуваарийн дагуу хүргүүлж байна.

Хавсралт 14 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Х.ЗОЛЖАРГАЛ

00000204

Жижиг албан бичиг 2014

## УЛСЫН ИХ ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДАЛ, САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас Улсын Их Хурлын хаврын чуулганаар:

1. “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн төсөл,
2. “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн төсөл,
3. “Тариалангийн даатгалын тухай хууль”-ийн төсөл
4. “Органик хүнсний тухай хууль”-ийн төсөл,
5. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл,
6. “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл,
7. “Тариалангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төсөл,
8. Төрөөс үйлдвэр, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого
9. Төрөөс хүнд үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг тус тус хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Үйлдвэр, хөдөө аж ахуйн Сайдын зөвлөлийн хуралдаанаар:

1. Малын генетик нөөцийн тухай хууль
2. Малын эрүүл мэндийн тухай хууль
3. “Малчдын орон сууц” хөтөлбөр;
4. Хөдөө аж ахуйн биржээр амьд мал арилжаалах
5. “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох түр журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах
6. 2013 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын дүн мэдээ /танилцуулга /
7. Үйлдвэрлэл, технологийн паркийн тухай хуулийн хэрэгжилтийн байдал /“Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн талаарх танилцуулга” цаашид авах арга хэмжээ / асуудлуудыг тус тус хэлэлцлээ.

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

## САЙНШАНД АЖ ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОР ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2013 оны 76 дугаар тогтоолоор "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолборын дэд бүтцийг хувийн хэвшлийн санал санаачилга, оролцоотой барьж байгуулахаар компанийн 66%-ийг хувийн хэвшилд санал болгохыг даалгаж, Хөгжлийн банкны санхүүжилтээр 14,1 тэрбум төгрөгийг судалгааны ажилд зарцуулахыг зөвшөөрсөн.

Төрийн өмчийн хорооны 2013 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 107 дугаар тогтоолоор "Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор" ХХК-ийг 34%-ийн төрийн оролцоотой хаалттай хувьцаат компани өөрчлөн зохион байгуулж дүрмийг баталж, Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталлаа.

Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ээлжит бус хурлын 2013 оны 05 сарын 27-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор байгуулах 3512.5 га, шинэ суурьшлын бүс байгуулах 508.9 га газрыг Дорноговь аймгийн газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтөөр оруулсан.

Дорноговь аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/325 тоот захирамжаар Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 3512.5 га газрыг "Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор" ХК-д эзэмшүүлсэн.

Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын бэлтгэл ажлын хүрээнд улсын төсвийн болон Хөгжлийн банкны санхүүжилтээр дараах ажлууд хийгдэж байна.Үүнд:

"Сайншандын аж үйлдвэрийн цогцолборын инженер-геологийн судалгаа явуулах", "Эрчим хүчний дэд станц барьж байгуулах ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна.

"Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулах ажлын хүрээнд Газар доорх усны нарийвчилсан хайгуулын ажил" тендерт "Тунгалаг ус" ХХК түншлэл шалгаран гүйцэтгэл 90%, "Бүс нутгийн хооронд ус тээвэрлэх боломжийн судалгаа ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах" тендерт "Монхидро" Констракшин ХХК шалгарч, гүйцэтгэл 90%, "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын бүсийн Байгаль орчны төлөв байдлын, нийгэм эдийн засгийн суурь судалгааг хийх" тендерт "Nature Friendly" ХХК шалгарч, гүйцэтгэл 40%, "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын хуулийн зөвлөхийг сонгон шалгаруулах" тендерт "Taylor Wessing" CoLtd, "Legal Policy" ХХК түншлэл шалгарч, гүйцэтгэл: 80%, "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын Төслийн ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах" тендерт "Flour" ХХК шалгарч, гүйцэтгэл 67 %, "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын Суурьшлын бүсийн хэсэгчилсэн төлөвлөгөө хийх" тендерт "Гоби травел" ХХК шалгарч, гүйцэтгэл 40% -ийн явцтай байна.

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

# ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Эрдэнэт хотын паркийн бүсийн үйлдвэрүүдтэй 2013 оны 6 дугаар сарын 18,19-ны өдрүүдэд Орхон аймагт ажиллаж, паркийн бүсэд үйл ажиллагаа явуулахаар санал ирүүлсэн аж ахуйн нэгжийн хөгжлийн төлөвлөгөөтэй танилцаж, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэртэй хамтран ажиллах чиглэлийг тохиров. /Сүү, сүүн бүтээгдэхүүн, бэлэг дурсгал, ганбөмбөлөгийг эхний ээлжинд нийлүүлэх боломжтой гэж үзэв./

Паркийн хуулийг хэрэгжүүлэх төрийн болон ТББ, эрдэм шинжилгээний байгууллагууд дунд болон Паркийн бүсэд татвар, эрхзүйн чиглэлээр 3-4 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Говь-Алтай, Баянхонгор аймаг, Багануур дүүрэгт сургалт, семинар зохион байгуулж 160 гаруй хүн хамруулсан.

Сумдад үйлдвэр технологийн парк байгуулах ажлын хүрээнд Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 226 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайд, Эдийн засгийн сайдын хамтарсан 76/59 дугаар тушаалын дагуу нэг маягийн загвар зураг төсөл боловсруулах 27 төрлийн зургийн ажлын даалгавар батлуулан, мэргэжлийн байгууллагаар зураг хийлгэлээ.

Ноос,ноолуурын болон Модны үйлдвэрийн дагнасан парк байгуулах, орон нутагт үйлдвэрлэл технологийн парк /ҮТП/ байгуулах, Багануур дүүргийн ҮТП-ийн нарийвчилсан судалгаа, ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг тус тус шалгаруулан гэрээ байгуулж, ажлыг хүлээн авсан.

Улаанбаатар, Дархан хотын гадна талд арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих арга хэмжээний төлөвлөгөө, тооцоог боловсруулж, үе шаттайгаар зохион байгуулах ажлын хэсгийг байгуулахаар оролцогч талуудтай зөвшилцсөн. Арьс, ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх, арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих асуудлаар Турк, Испани, Франц, Израйль, Япон, Голланд, Хятадын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, харьцуулсан судалгаа хийгээд байна.

Өмнөх онуудад хийгдсэн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутгийн заагт 50 га газарт “Арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах дэд бүтцийг барих Техник эдийн засгийн үндэслэл судалгаа” тодотгож, цаашид хийх шаардлагатай ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Ажлын үр дүнг Ерөнхий сайдад танилцуулж, Арьс ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах байршлыг дахин судалж тогтоох үүрэг өгсний дагуу Засгийн газрын 2013 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 249 дүгээр тогтоол гарсан.

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд “Дархан-Уул аймагт байгуулах Арьс ширний үйлдвэрлэлийн парк, цогцолборын мастер төлөвлөгөө, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах” зорилгоор Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай ” хуульд нийцүүлэн сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажлыг хүлээн авсан.

Дархан, Эрдэнэт хот Багануур дүүргийн паркийн бүсэд үйл ажиллагаа явуулж татварын хөнгөлөлтөд хамрагдах ААН-ийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу паркийн бүсэд үйл ажиллагаа явуулах салбар, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг батлуулахаар Сайдын тушаалын төсөл, паркийн нэгжийн удирдлагын Сайдтай байгуулах гэрээний төсөл боловсруулан, танилцуулга бэлтгэж 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Сайдын зөвлөлийн хуралдаанаар танилцуулж чиглэл авав. Энэ ажлын хүрээнд паркийн бүсэд үйл ажиллагаа явуулах хүнд, хөнгөн, хүнсний чиглэлийн 30 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлт, борлуулалт, нэмэгдүүлэх ажлын байрны тоог тодорхойлов.

"Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай" хуулийн 10.2, "Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлд заасан нөхцлийг хангаж төслөө ирүүлсэн аж ахуйн нэгж Эрдэнэттехнопаркад 8, Багануурын паркийн бүсэд 10, Дарханы паркийн бүсэд 12 байгаа ба эдгээр аж ахуйн нэгжүүд энэ онд 3244 хүнийг ажлын байраар хангаж, 63 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бол 2016 он гэхэд бүтээгдэхүүний нэр төрөл 2 дахин нэмэгдүүлж, 6200 ажлын байр бий болгон 258 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өсөлт гаргахаар төлөвлөсөн байна.

Нийслэлийн Засаг даргын А/932 дугаар захирамжаар байгуулагдсан Нийслэлийн алсладсан дүүрэг Багануур, Багахангай, Налайх, Шинэ суурьшлын бүсэд байгуулагдах ҮТП-ийн бүсийн салбаруудын үндсэн чиглэлийг тодорхойлох, барьж байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд яам, нийслэлтэй хамтран ажиллах төлөвлөгөөний төсөл боловсруулж одоогоор Шинэ суурьшлын бүсэд Хөнгөн аж үйлдвэрийн парк, Багахангай дүүрэгт тенант парк, Налайх дүүрэгт барилгын материалын үйлдвэрийн дагнасан парк байгуулах чиглэлийг тогтоохоор төсөл боловсруулж байна.

ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНААР 2014 ОНД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэлэлцүүлэх асуудлын агуулга | Үндэслэл | Улирал | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эцэслэж гарах шийдвэр | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Улсын сайн малчин, улсын тэргүүний малчдын бүлэг, улсын тэргүүний фермер шалгаруулах тухай | Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоол | Засгийн газрын тогтоол | 2014.01.25 | | | |
| 2. | Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөрийн тайлангийн танилцуулга | Засгийн газрын 2007 оны 255 дугаар тогтоол | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.01.25 | | | |
| 3. | Төмс, хүнсний ногоо хөтөлбөрийн төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.5, 93 дахь заалтууд | Засгийн газрын тогтоол | 2014.02.15 | | | |
| 3. | Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 78.4. дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.02.22 | | | |
| 4. | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 78.4. дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.02.22 | | | |
| 5. | Зарим төрийн өмчит компанийг өөрчлөн байгуулах тухай /"Хөрс агрохимийн улсын төв лаборатори", "Борнуур сорт сорилтын төв", "Номгон сорт сорилт", "Найрамдал сорт сорилт" болон "Алтан гангага" төрийн өмчит үйлдвэрийн газар/ | Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 93.2 дахь заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.01 | | | |
| 6. | Малчдын хоршооны мастер төлөвлөгөөний төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3 дахь заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.01 | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | Органик хүнсний тухай хуулийн төсөл | Хүнсний тухай хуулийн 16.4 дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.03.01 | | | |
| 8. | Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төсөл | Хүнсний тухай хуулийн 16.4 дэх заалт Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 242.1. дэх заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.01 | | | |
| 9. | Мал аж ахуйн хаваржилтийн нөхцөл байдлын талаар танилцуулга | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.03.22 | | | |
| 10. | Стратегийн хүнсийг экспортлох, импортлоход зөвшөөрөл олгох түр журамд нэмэлт өөрчлөлт оруулах | Хүнсний тухай хуулийн 6.7 дахь заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.29 | | | |
| 11. | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл 2003 оны Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.03.29 | | | |
| 12. | Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай /Уулуурхайнэцсийнбүтээгдэхүүнүйлдвэрлэхүйлдвэрийнүндсэнтоногтөхөөрөмжийггаалийнболон НӨАТ-аасчөлөөлөх/ | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 49.3 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 2014.03.29 | | | |
| 13. | Монголд хүрээлэн буй орчинд ээлтэй тээврийн хэрэгсэл үйлдвэрлэх хөтөлбөрийн төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 50.3 дахь заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.29 | | | |
| 14. | Дархан Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордын ашиглалтын асуудал болон зарим ордны эзэмшлийн ордын талаар авах арга хэмжээний тухай | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 50.1 дахь заалт | Засгийн газрын тогтоол | 2014.03.29 | | | |
| 15. | Тариалангийн тухай хуулийн төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 93 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | 2013.04.05 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16. | Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4 дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | 2014.04.26 | | |
| 17. | Хаврын тариалалтын бэлтгэл хангасан дүнгийн танилцуулга | Тариалангийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | 2013.05.10 | | |
| 18. | Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл | Хүнсний тухай хуулийн 9.3,8.1,8.1.4 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | 2014.06.07 | | |
| 19. | Малчдын орон сууц үндэсний хөтөлбөрийн төсөл | Их хурлын 2009 оны 39 дүгээр тогтоол Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 3.2.10 дахь заалт,МонголУлсынЗасгийнгазрын 2012-2016 оныүйлажиллагааныхөтөлбөрийгхэрэгжүүлэхаргахэмжээнийтөлөвлөгөөний 3.78.5 заалт | Засгийн газрын тогтоол | | 2014.06.14 | | |
| 20. | Төрийн өмчийг 2012-2016 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.5 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | 2014.06.21 | | |
| 21. | Зүүн бүсийн тариаланг хөгжүүлэх төсөл | Үндэсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийн 14.7 дэх заалт | Засгийн газрын тогтоол | | 2014.06.21 | | |
| 22. | Тариалалтын эцсийн дүн | Тариалангийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | 2014.07.05 | |
| 23. | Мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг | Засгийн газрын тогтоол | | | 2014.07.05 | |
| 24. | Ургацын урьдчилсан балансын танилцуулга | Тариалангийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | 2014.08.30 | |
| 25. | Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл | МонголУлсынЗасгийнгазрын 2012-2016 оныүйлажиллагааныхөтөлбөрийгхэрэгжүүлэхаргахэмжээнийтөлөвлөгөө 93.1 дахь хэсэг | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | 2014.09.06 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26. | Махны салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөний төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 68.1,77.1,77.2,77.4,270.1,77.5 дахь заалтууд | Засгийн газрын тогтоол | | | 2014.09.06 | |
| 27. | Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл | УИХ-ын 2012 оны 23 дугаар тогтоолын 3.1.13 дахь заалт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 78.4. дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | 2014.09.20 | |
| 28. | Сав баглаа боодлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай | 2013 оны 11 сард зохион байгуулагдсан “Сав баглаа боодол-2014” үзэсгэлэнгийн үеэр Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгавар | Засгийн газрын тогтоол | | | 2014.09.20 | |
| 29. | Хүнсний чиглэлийн үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэгийн тухай журмын төсөл | Хүнсний тухай хуулийн 8 дугаар зүйл 8:5 дахь заалт | Засгийн газрын тогтоол | | | 2014.09.20 | |
| 30. | Төрийн өмчийн оролцоотой ой модны цогцолбор үйлдвэр байгуулах тухай /Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараагийн МБҮ-ийг түшиглэн төрийн өмчийн оролцоотой ой, модны цогцолборүйлдвэр/ | “Ойн үндэсний хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2011 оны 113-р тогтоолын 2.1.2 дах заалт | Засгийн газрын тогтоол | | | | 2014.10.04 |
| 31. | Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын төсөл | МУ-ын ЗГ-ын 2012-2016 оныүйлажиллагааныхөтөлбөрийгхэрэгжүүлэхаргахэмжээнийтөлөвлөгөө 1.12 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | 2014.11.15 |
| 32. | Хөнгөн үйлдвэрийн талаар төрөөс баримтлах бодлогын төсөл | Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 30.1 дэх заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | 2014.12.06 |
| 33. | Ургац хураалтын дүнгийн танилцуулга | Тариалангийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | 2014.12.13 |
| 34. | Хүнсний биотехнологийн хөгжил хөтөлбөрийн төсөл | УИХ-ын 2008 оны тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын | Засгийн газрын тогтоол | | | | 2014.12.13 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хөдөөажахуй, хүнснийүйлдвэрлэлийнхөгжлийнбодлогын хүрээ, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 72.3дахь заалт | | | | | |
| 35. | Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг худалдах, шилжүүлэх, хувьчлах тухай | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9.3 дахь заалт, Орон сууц хувьчлах тухай хуулийн 6.3 дахь заалт. | Засгийн газрын тогтоол | | | | 2014.12.19 |

................oOo..................

## ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ 2013 ОНД ХИЙГДСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2013,12,31 /сая төгрөг/

| Дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил | Хугацаа | | Төсөвт өртөг | 2013 онд санхүүжих | Санхүүжилт | 2014 онд санхүүжих | Хэмнэлт үлдэгдэл | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| XXYII | ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД | | | 125,469.0 | 54,846.0 | 35,350.1 | 14,750.8 | 4,745.1 | |
| XXYII.1 | Хөрөнгө оруулалт: | | | 55,812.2 | 21,537.3 | 13,754.0 | 7,240.3 | 542.9 | |
| | Шилжих: | | | 52,922.2 | 18,833.4 | 11,565.5 | 6,869.0 | 398.8 | |
| XXYII.1.1 | Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа" төслийн дотоод эх үүсвэр | 2012 | 2016 | 3,917.2 | 100.0 | 100.0 | 0.0 | 0.0 | Монгол Улсын Засгийн газрын оролцоо буюу Улсын төсвийн хөрөнгө 100,0 сая Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламжийн хөрөнгө 515,2 сая нийт 615,2 сая төгрөгөөр инженерийн хийцтэй 28 худаг шинээр гаргах, 4 худаг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчээр "Танан импекс" ХХК, "Гранд электро техноком" ХХК-иуд шалгарсан. Инженерийн хийцтэй худаг барьж байгуулах ажил хийгдэж дууссан. |
| XXYII.1.2 | Хүнсний лаборатори байгуулах /Улаанбаатар/ | 2012 | 2013 | 4,300.0 | 3,135.0 | 3,133.9 | 0.0 | 1.1 | 2012 оны төсвийн тухай хуулиар тус лабораторийг байгуулах төсөвт өртөг 4,3 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тендер зарлан шалгарсан. Медимпекс ХХК-тай гэрээ байгуулан 2012 онд урьдчилгаа санхүүжилт 1,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2013 онд 3,1 тэрбум төгрөг нийт 4,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. |
| XXYII.1.3 | Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Бүх аймагт/ | 2011 | 2015 | 26,584.0 | 6,523.4 | 3,474.8 | 2,808.0 | 240.6 | Инженерийн хийцтэй худаг гаргах худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулахаар эрхийг аймгийн засаг дарга нарт шилжүүлсэн байна. Худаг гаргах хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулаад байна. Орон нутагт инженерийн хийцтэй 406 худаг гарч улсын комисс үлээн авсан байна. Орон нутгаас ирүүлсэн 2,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл СЯ-нд хүргүүлсэн боловч СЯ-наас эрх нээгдэн санхүүжилт хийгдээгүйгээс эцсийн санхүүжилт хийгдээгүй байна. |
| XXYII.1.4 | Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | 2012 | 2013 | 650.0 | 425.0 | 225.0 | 200.0 | 0.0 | Барилга, байгууламжийн угсралтын ажлын гэрээг тендерт шалгарсан "Ди Си Эйч" ХХК-тай гэрээ байгуулсан барилга угсралтын ажил хуваарийн дагуу хийгдэж байна. 2013 оны үлдэгдэл санхүүжилт ЗГ тэмдэглэлийн дагуу дараа онд санхүүжхээр шийдвэрлэгдсэн байна. 2014 онд "Монгол Улсын 2014 оны төсвийн тухай" хуулийн дагуу санхүүжнэ. |
| XXYII.1.5 | Малын удмын сангийн үндэсний цогцолбор /Дархан-Уул, Хонгор/ | 2012 | 2015 | 12,271.0 | 3,500.0 | 3,460.2 | 0.0 | 39.8 | "Малын удмын сангийн үндэсний цогцолбор"-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Набсан" ХХК-тай гэрээ байгуулсан барилга угсралтын ажил хуваарийн дагуу хийгдэж байна. 2014 онд "Монгол Улсын 2014 оны төсвийн тухай" хуулийн дагуу санхүүжигдэнэ. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| XXYII.1.6 | Түүхий эд, бүтээгдэхүүний бирж байгуулах, түүхий эдийн агуулах байгуулах /Улаанбаатар, бүх аймгууд/ | 2012 | 2013 | 5,000.0 | 5,000.0 | 1,021.7 | 3,861.0 | 117.3 | Засгийн газрын 30 дугаар тогтоолоор "Хөдөө аж ахуйн бирж" төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулан биржийн арилжааг эхлүүлээд байна. "Хөдөө аж ахуйн бирж" Төрийн өмчит хуулийн этгээдэд оруулах хөрөнгөнд шилжүүлэх шийдвэрийг гаргуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулан шалгарсан "NOSDAC" группэй гэрээ байгуулж, гэрээг дүгнэж гүйцэтгэлийн СЯ-нд хүргүүлсэн боловч СЯ-наас эрх нээгдэн санхүүжилт хийгдээгүйгээс эцсийн санхүүжилт хийгдээгүй байна. |
| XXYII.1.7 | Бэлчээр усжуулах зорилгоор гүний өрмийн худагт салхин сэнсэн шахуурга суурилуулах /Дорноговь, Говьсүмбэр/ | 2012 | 2013 | 200.0 | 150.0 | 150.0 | 0.0 | 0.0 | Дорноговь, Говьсүмбэр аймгуудын 15 худагт салхин сэнсний шахуурга суурилуулах тендер зарлан гүйцэтгэгчээр "Хан мокор" ХХК шалгаран гэрээт ажил хуваарийн дагуу хийгдэж бүрэн дууссан Санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |
| | Шинэ: | | | 2,890.0 | 2,703.9 | 2,188.5 | 371.3 | 144.1 | |
| XXYII.1.8 | Буянт голын услалтын систем /Ховд/ | 2013 | 2013 | 2,000.0 | 1,854.0 | 1,482.7 | 371.3 | 0.0 | "Буянт голын услалтын систем"-ийн ажлын гүйцэтгэгчээр "Монгол менежмент төв" ХХК шалгаран ажил хуваарийн дагуу хийгдэж Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Эцсийн гүйцэтгэлийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч эрх нээгдэн санхүүжилт хийгдээгүйгээс эцсийн санхүүжилт хийгдээгүй байна. |
| XXYII.1.9 | Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын барилга /Сүхбаатар, Баруун-Урт/ | 2013 | 2013 | 890.0 | 849.9 | 705.8 | 0.0 | 144.1 | 2012 онд барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Хатан тууЙ хөгжил" ХХК-тай гэрээ байгуулсан барилгын ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна. Улсын комисст хүлээлгэн өгсөн байна. Санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |
| **XXYII.2** | **Их засвар:** | | | **1,648.8** | **1,362.1** | **1,288.7** | **48.3** | **25.1** | |
| XXYII.2.1 | Мал эмнэлгийн лабораторийн засвар /Булган, Өвөрхангай/ | 2013 | 2013 | 55.0 | 55.0 | 4.9 | 48.3 | 1.8 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарт худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрхийг шилжүүлсэн. Орон нутагт тендерт шалгаран гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэл ирүүлснээр засварын ажил бүрэн дууссан байна. Булган аймгийн Мал эмнэлгийн лабораторийн засварын ажил бүрэн дууссан боловч гүйцэтгэгч "Цонохт" ХХК-ны эцсийн гүйцэтгэлийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч Сангийн яамнаас эрх нээгдэн санхүүжилт хийгдээгүйгээс эцсийн санхүүжилт хийгдээгүй байна. Бусад засварын ажлын санхүүжилт бүрэн хийгдэж дууссан байна. |
| XXYII.2.2 | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Говь-Алтай, Дорнод/ | 2013 | 2013 | 30.4 | 30.4 | 30.4 | 0.0 | 0.0 | |
| XXYII.2.3 | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Дорноговь/ | 2011 | 2013 | 99.8 | 54.3 | 54.3 | 0.0 | 0.0 | |
| XXYII.2.4 | Мал эмнэлгийн лабораторийн засвар /Дундговь/ | 2011 | 2013 | 178.0 | 170.0 | 169.3 | 0.0 | 0.7 | |
| XXYII.2.5 | Мал эмнэлгийн лабораторийн засвар /Завхан/ | 2011 | 2013 | 370.9 | 256.6 | 255.9 | 0.0 | 0.7 | |
| XXYII.2.6 | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар болон Мал эмнэлгийн лабораторийн засвар /Өмнөговь/ | 2013 | 2013 | 157.9 | 157.9 | 151.0 | 0.0 | 6.9 | |
| XXYII.2.7 | Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны 250 хүний суудалтай хурлын заалны засвар /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ | 2013 | 2013 | 445.0 | 399.8 | 390.8 | 0.0 | 9.0 | |
| XXYII.2.8 | Мал эмнэлгийн лабораторийн засвар /Сүхбаатар/ | 2011 | 2013 | 63.7 | 25.0 | 25.0 | 0.0 | 0.0 | |
| XXYII.2.9 | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын засвар /Төв, Говьсүмбэр/ | 2013 | 2013 | 13.1 | 13.1 | 13.0 | 0.0 | 0.1 | |
| XXYII.2.10 | Мал эмнэлгийн лабораторийн барилгын их засвар /Хэнтий/ | 2013 | 2013 | 50.0 | 50.0 | 48.9 | 0.0 | 1.1 | |
| XXYII.2.11 | Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын их засвар /Дархан-Уул/ | 2011 | 2013 | 185.0 | 150.0 | 145.2 | 0.0 | 4.8 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **XXYII.3** | **Тоног төхөөрөмж:** | | | **3.319.0** | **1.127.5** | **527.5** | **598.5** | **1.5** | |
| XXYII.3.1 | Мал эмнэлгийн ариутгал халдваргүйтлийн арга хэмжээг хэрэгжүүлэх, өвчтэй малыг халдвар дамжуулахгүйгээр нядлах тоног төхөөрөмж /Монгол мал үндэсний хөтөлбөр/ | 2011 | 2013 | 1,200.0 | 600.0 | | 598.5 | 1.5 | Мал эмнэлгийн хог хаягдал, малын сэг зэмийг шатаах, устгах зуух нийлүүлэхээр "Промтех сервис" ХХК-тай гэрээ байгуулсан. Барааг "Төсвийн тухай" хуулийн 43 дугаар зүйлийн 43,4-т заасны дагуу 2014 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор хийлгэхээр гэрээнд тусгасан боловч энэ хэсгийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон тул 2013 оны төсвөөс санхүүжилт хийх боломжгүй болсон байна. 2014 онд гүйцэтгэлээр санхүүжүүлхээр шийдвэрлсэн байна. |
| XXYII.3.2 | Үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн шинэчлэл | 2012 | 2013 | 2,030.0 | 438.5 | 438.5 | 0.0 | 0.0 | Үйлдвэр, хөдөө аж ахуйн байгууллагуудын тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийхээр тендер зарлан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуусан байна. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаандаа нийлүүлсэн тул санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |
| XXYII.3.3 | Төрийн өмчийн хорооны тоног төхөөрөмж | 2013 | 2013 | 89.0 | 89.0 | 89.0 | 0.0 | 0.0 | Төрийн өмчийн хорооны тоног, төхөөрөмжийн шинэчлэл хийхээр тендер зарлан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуусан байна. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжийг гэрээнд заасан хугацаандаа нийлүүлсэн тул санхүүжилт бүрэн хийгдсэн байна. |
| **XXYII.4** | **Техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл;** | | | **15,240.0** | **10,539.8** | **3,704.4** | **2,660.0** | **4,175.4** | |
| XXYII.4.1 | Үйлдвэр технологийн парк байгуулах судалгаа, зураг төсөл, био-технологийн лабораторийг чадавхижуулах, Нано технологийн төв болон лаборатори байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах | 2013 | 2013 | 590.0 | 323.7 | 322.9 | 0.0 | 0.8 | Орон нутагт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах зураг, төсөл, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Бегофарбен" ХХК-тай, Ноос, ноолуурын салбарын ҮТПарк байгуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Цагчигт-цогц"ХХК-тай, Модны салбарын цогцолбор ҮТПарк байгуулах судалгаа, ажлын зураг ТЭЗҮ боловсруулах гэрээг "Ой модны үйлдвэрлэл эрхлэгчдийн холбоо"-той, Арьс ширний лабораторийг чадавхижуулах судалгаа, ТЭЗҮ боловсруулах гэрээг "Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнтэй тус тус байгуулан ажилласан байна. ТЭЗҮ-г бүрэн хүлээн авч санхүүжилт хийгдсэн байна. |
| XXYII.4.2 | Загасны үйлдвэр байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах /Завхан, Архангай, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл/ | 2013 | 2013 | 50.0 | 50.0 | 49.6 | 0.0 | 0.4 | Гүйцэтгэгчээр шалгарсан "Солорхаус"ХХК-тай гэрээ байгуулан ажилласан. Ажил хуваарийн дагуу хийгдэж гэрээнд заасан хугацаандаа ТЭЗҮ-ийг бүрэн хүлээлгэн өгсөн тул санхүүжилт хийгдсэн байна. |
| XXYII.4.3 | Таримал ургамлын элит үр үржүүлэг, шинэ сортыг бий болгох, нутагшуулах, сорт сорилт, судалгааны ажлыг эрчимжүүлж, үрийн чанар хангамжийг сайжруулах; | 2013 | 2013 | 3,000.0 | 846.3 | 434.2 | 0.0 | 412.1 | "Таримал ургамлын үр үржүүлэг, таримлын сэлгээ, шинэ сортуудыг сорих, нутагшуулах, сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх" "Алслагдсан бүсэд газар тариаланг сэргээн хөгжүүлэх" ТЭЗҮ боловсруулах гэрээг Монголын хөдөгөг шинэчлэх фермерүүдийн холбоотой байгуулсан мөн "Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг зун намрын улирлд Улаанбаатар хотын дүүргүүдэд худалдан борлуулахад зориулсан агуулах, худалдааны төв байгуулсан ажил хуваарийн дагуу хийгдэж хүлээлгэн өгсөн байна. санхүүжилт хийгдэж дууссан. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| XXYII.4.4 | Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах бэлтгэлийг хангах, нүүрснээс шингэн түлш, хий гаргах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах | 2013 | 2013 | 2,900.0 | 1,500.0 | | 1,498.0 | 2.0 | "Нүүрснээс шингэн түлш, хий үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах гэрээг "Техностарт" ХХК-тай байгуулсан. ТЭЗҮ-ийг "Төсвийн тухай" хуулийн 43 дугаар зүйлийн 43,4-т заасны дагуу 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хийлүүлхээр гэрээн тусгасан боловч энэ хэсгийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон тул 2013 оны төсвөөс санхүүжилт хийх боломжгүй болсон байна. 2014 онд гүйцэтгэлээр санхүүжүүлхээр шийдвэрлсэн байна |
| XXYII.4.5 | Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор болон Багануур, Дарханы үйлдвэр технологийн паркийн захиргаа байгуулах, ерөнхий төлөвлөгөө боловсруулах /Дорноговь, Улаанбаатар, Дархан-Уул/ | 2013 | 2013 | 8,700.0 | 7,819.8 | 2,897.7 | 1,162.0 | 3,760.1 | Тус ажлыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж "Сайншанд аж үйлдвэрийн цогцолборын газар доорхи усны нарийвчилсан хайгуулын ажил" хийх гэрээг "Тунгалаг ус" ХХК-тай байгуулсан ажил хуваарийн дагуу хийгдэж байна. 2013 оны батлагдсан төсвөөс урьдчилгаа санхүүжилт хийгдсэн байна. Эцсийн санхүүжилтийг гүйцэтгэлээр "Төсвийн тухай" хуулийн 43 дугаар зүйлийн 43,4-т заасны дагуу 2014 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор ажил бүрэн хүлээлгэн өгсөнөөр нээгдэнэ гэж гэрээн тусгасан боловч хуулийн энэ хэсгийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон тул эцсийн санхүүжилтийг 2014 онд гүйцэтгэлээр санхүүжүүлхээр шийдвэрлсэн байна |
| **XXYII.5** | **Хөрөнгийн шилжүүлэг, дэмжлэг** | | | **49,449.0** | **20,279.3** | **16,075.5** | **4,203.7** | **0.1** | |
| XXYII.5.1 | Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах /Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Булган, Улаанбаатар, Увс, Хөвсгөл, Дорнод/ | 2012 | 2013 | 20,500.0 | 4,789.2 | 3,182.9 | 1,606.3 | 0.0 | Газар тариалангийн бүтээгдэхүүний агуулах байгуулах 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд хуваарилаж гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн ирүүлсэн гүйцэтгэлээр санхүүжилтыг олгож байна. Гэрээн ажил дууссан байна. |
| XXYII.5.2 | Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих /Зураг төсөв боловсруулах/ | 2012 | 2013 | 6,800.0 | 6,681.0 | 4,589.6 | 2,091.4 | 0.0 | Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барихаар 6,8 тэрбум төгрөгөөс 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 2,9 тэрбум төгрөгийг хуваарилаж, 3,9 тэрбум төгрөгөөр Төрийн болон орон нутгийн өмчийн услалтын системийг шинээр барих, сэргээн засварлах болон Усалгаатай тариалан, хадланд тохиромжтой талбайн хайгуул судалгаа хийх, төрийн ба орон нутгийн өмчийн услалтын системийн зураг төсөл зохиох зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулан ажиллаж гэрээ байгуулсан ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна. |
| XXYII.5.3 | Сум дундын загвар нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх | 2013 | 2013 | 400.0 | 396.2 | 396.2 | 0.0 | 0.1 | Сум дундын загвар нядалгааны цех байгуулах ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулан "Немон"ХХК-тай гэрээ байгуулсан ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна. |
| XXYII.5.4 | Төмс, хүнсний ногоо, тариалангийн техникийн шинэчлэл | 2012 | 2013 | 7,000.0 | 5,423.0 | 5,423.1 | 0.0 | -0.1 | 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 3,5 тэрбум төгрөгийг хуваарилаж, 2,5 тэрбум төгрөгөөр Төмс, хүнсний ногоо үйлдвэрлэлийн зориулалттай бага оврын техник, тоног төхөөрөмж болон Хүнсний ногооны үрслэг суулгах зориулалттай машин худалдан авах тендерийг Худалдан авах ажиллагааны газар шалгаруулж шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК, "Агро трейд импекс" ХХК, "Сонг Ху Ти Эс" ХХК-уудтай гэрээ байгуулаад байна. Ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| XXYII.5.5 | Хүнсний ногооны хүлэмжийн аж ахуй байгуулах | 2012 | 2013 | 1,000.0 | 990.0 | 483.9 | 506.0 | 0.1 | 2012 оны тендерийн үлдэгдэл санхүүжилтэд 484,0 сая төгрөгийг хуваарилаж, 516,0 сая төгрөгөөр 240 м2 талбай бүхий нийлэг хальсан хүлэмж болон Гүзээлзгэнэ тарихад зориулагдсан 1050 м2 талбайтай, автомат ажиллагаатай, давхар хүлэмж худалдан авхаар тендер шалгаруулж шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК-тай гэрээ байгуулаад байна. Ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна. |
| XXYII.5.6 | Малын тэжээлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж (Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй аймаг, сум, хот суурин газрууд) | 2012 | 2017 | 13,749.0 | 1,999.9 | 1,999.9 | 0.0 | | Хүчит тэжээлийн цех, Ногоон тэжээл үйлдвэрлэх тоног төхөөрөмж, Өвс хуйлж боох хаман боогч техник худалдан авах тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулан "Тэнүүн хас"ХХК, "Нью фоос"ХХК-уудтай гэрээ байгуулсан байна. Ажил хуваарийн дагуу хийгдэж дууссан байна. |